



ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

(2023-2025 он)

Арвайхээр 2023 он

1. Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10/03 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулах хөтөлбөр 2022-2025”-ийг тус тус үндэслэн БОЭТ-ийн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг 2023-2025 оныг дуустал 3 жилийн хугацаатай хэрэгжихээр боловсрууллаа.

Өвөрхангай аймаг дахь БОЭТ-ийн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг захирлын 2018 оны А/61 дугаар тушаалаар батлаж 2018-2020 онд амжилттай хэрэгжүүлэн ажилласан. Тус хөтөлбөрийн үр дүнд хүүхэд, нярай, сэтгэц, мэдрэл, мэс засал, мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээ, дотор, яаралтай тусламжийн эмчээр хангагдсан байна. Мөн эрчимт эмчилгээ, нярай, хүүхэд, яаралтай тусламж, мэс засал, мэдээгүйжүүлгийн сувилагч нарыг төрөлжсөн мэргэшлийн сургалтад хамруулан мэргэшүүлсэн.

Эмч нарын 102 буюу 81,6% нь үндсэн, 60 буюу 48% нь төрөлжсөн мэргэшил эзэмшсэн. Сувилагч тусгай мэргэжилтний 144 буюу 61,5% нь төрөлжсөн мэргэшил эзэмшсэн. Мэргэшлийн зэрэг, цолтой эмч, эмнэлгийн мэргэжилтэн 128 (26.5%) ажиллаж байна. Зөвлөх зэрэг 4 эмч, 1 эх баригч хамгаалсан.

Хүний нөөцийн мэдээллийн цахим санд баяжилт хийн цалингийн сантай холболт хийж сар бүрийн цалинг Хүний нөөцийн мэдээллийн сангаас татаж олгох болсон. Мөн хүний нөөцийн тайлан, мэдээ, судалгаа гаргахад тус программыг ашиглаж хэвшсэн.

БОЭТ-ийн хүний нөөцийн тулгамдсан асуудал, хүний нөөцийн хангалт, байршуулалтанд онцгой анхаарч, тогтвор суурьшилтай ажиллуулах, ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, ур чадварыг хөгжүүлэх болон ажиллах нөхцлийг сайжруулах, ЭМСалбарын өөрчлөлт, шинэчлэл нь эрүүл мэндийн байгууллагуудын зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд мэдлэг чадвартай хүний нөөцөөр бэхжүүлэн, өрсөлдөгч байгууллагаас ялгарах давуу талыг бий болгох, иргэдэд ойр, уян хатан, үр дүнд чиглэсэн чанартай эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх хариуцлагын шинэ тогтолцоог бий болгож өмнө жилүүдээс улам илүү их мэдлэг чадвар бүхий хүний нөөцийг хөгжүүлэх нь уг хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна

Эмчилгээ оношилгооны шинэ технологи, техник технологи хурдацтай нэвтэрч байгаа өнөө үед эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэхэд орчин үеийн мэргэшсэн өндөр мэдлэгтэй эмч, мэргэжилтэнг бэлтгэх шаардлага нэн тэргүүний асуудал болж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго:

Эрүүл мэндийн салбарын тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх болон өөрчлөлт шинэчлэлтэд зохицож чадах үнэт зүйлс, мэдлэг, чадвар, хандлага бүхий чадавхи сайтай, нийгмийн баталгаа хангагдсан, ёс зүйн төлөвшилтэй хүний нөөцийг хөгжүүлэхэд оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилтууд:

1. Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтний хэрэгцээг тодорхойлж, хангалтыг сайжруулах, оновчтой байршуулах
2. Эмч, мэргэжилтнүүдийг төгсөлтийн дараах сургалтанд хамруулах, мэдлэг, ур чадварыг сайжруулах
3. Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлөөр хангах
4. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг төлөвшүүлэх, ажлын хариуцлагыг сайжруулах

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа:

2023-2025 онуудад

БОЭТ-ийн хүний нөөцийн өнөөгийн нөхцөл байдал:

2023 онд 517 орон тоо батлагдсан. Үүнээс

- их эмч 129,
- сувилагч эмнэлгийн мэргэжилтэн 267,
- бусад ажилтан 121

2023 оны байдлаар

- их эмч 113
- сувилагч эмнэлгийн мэргэжилтэн 238,
- бусад ажилтан 121 ажиллаж байна. Их эмчийн дутагдал нь дүрс оношилгооны эмч, лабораторийн эмч, эмгэг судлалын эмч, Настан судлалын эмч, шүдний эмч, сувилагч, лаборантын дутагдалтай ажиллаж байна.

Сургалт хөгжил: 2016-2022 онд Төгсөлтийн дараах сургалтад хамрагдагсад нийт 179 (37,3%), Гадаад сургалт, аялалд нийт 57, Төгсөлтийн дараах сургалтад 100% цалинтай сургасан. Дагалдан суралцах арга хэмжээг хэрэгжүүлсэн-ГССҮТ, УНТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ хамтран зохион байгуулсан. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах Сургалт эрхлэх байгууллага болсон. Орон нутагтаа сувилахуйн сургуулийн элсэлт авч эхлэсэнээр сувилахуйн дадлага хийх сургалтын бааз сууриар хангагдсан.

Эмнэлзүйн сургагч багш 22, сувилахуйн сургагч багш 10 бэлтгэгдсэн байна.

Мөн 2022 оны байдлаар зөвлөх зэргийн эмч 3, тэргүүлэх зэргийн эмч 20, ахлах зэргийн эмч 15 ажиллаж байна. Сувилагч эмнэлгийн мэргэжилтний хувьд 31,3% нь мэргэшлийн зэрэгтэй үүнээс зөвлөх зэргийн эх баригч 1 байна.

Эмнэлгийн ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, нийгмийн баталгааг хангахыг зорьж “Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны албан тушаалын зэрэглэл, шатлал, үндсэн цалингийн сүлжээ”-г эмнэлгийн захирлын тушаалаар нэмэгдүүлэн тогтоосон. Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс ба урамшууллыг цаг хугацаанд нь олгож байна. Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны цалинг Засгийн газрын тогтоолоор баталсан ТҮЭМ, ТҮ-ийн албан хаагчийн цалингийн доод жишгээс бууруулаагүй ба Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоол болон төр, захиргааны дээд байгууллагуудаас гарсан хүчинтэй тушаал, журмыг үндэслэн албан тушаалын, эрдмийн ба мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын нэмэгдэл, нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамны сайдын тушаалд заагдсан хүнд, хортой нөхцөлд ажиллаж байгаа эмнэлгийн ажилтнуудад тус журамд заасны дагуу хөнгөлөлт эдлүүлдэг.

Ээлжийн ажилчдаас хамаарахгүйгээр шөнийн цагаар жижүүрт ажилласан ажилтан, ажлын өдөр илүү цагаар болон 7 хоногийн амралт, нийтээр амрах баяр ёслолын өдөр ажиллуулаад нөхөн амруулаагүй үед үндсэн цагийн тарифт цалингийн 2,0 дахин, нийтээр амрах баярын өдөр нөхөн амруулаагүй бол 2,0 дахин нэмэгдүүлэн олгодог.

Байгууллагын дотоод журамд заасны дагуу ажилтнуудад өрх толгойлсон, гачигдал, болон гадаад болон дотоодын мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтанд хамрагдсан үед буцалтгүй тэтгэмж, тэтгэмжтэй чөлөө, ахмад ажилтанд тэтгэмж тус тус олгож байна.

Ажилтнуудын чөлөөт цагийг зөв өнгөрүүлэн, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор эмнэлгийн үйлдвэрчний хороотой хамтран 7 хоног бүрийн 1 өдөр сагс, волейбол секц ажиллуул ирсэн. Ажлын байрны тав тух, аюулгүй байдлыг хангах хүрээнд урсгал засварыг батлагдсан төсвийн хүрээнд жил бүр тогтмол төлөвлөж хийж байна. Ажилтнуудыг жил бүр батлагдсан төсвийн хүрээнд ажлын хувцас, хөдөлмөр хамгаалалын хэрэгслээр хангаж байна. Бүх эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудад хөнгөлөлттэй үнээр өдрийн халуун хоол, өвлийн улиралд халуун арц, чацарганы шүүс олгож байна.

Орчны шинжилгээ СВОТ шинжилгээ

Хүснэгт 1. Хүний нөөцийн свот шинжилгээ

ДАВУУ ТАЛ 1. Сургалт эрхлэх байгууллага эрхийг 2022 онд авсан. 2. Эмнэлзүйн сургагч багш бэлтгэгдсэн. 3. Сувилахуйн сургагч багш нар бэлтгэгдсэн. 4. Үндсэн мэргэшлийн сургалт явуулж эхэлсэн. 5. Бүсийн хэмжээнд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлдэг. 6. Сувилахуйн сургалтын дадлагын бааз сууриар хангагдсан. 7. Гүйцэтгэлийн санхүүжилтээр санхүүжиж байгаатай холбоотой эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажилчдын цалинг гүйцэтгэлээр үнэлж олгох боломжтой 8. БОЭТ-ийн эмч нарийн 98,8 хувь төрөлжсөн нарийн мэргэшил эзэшсэн.	СУЛ ТАЛ 1. Орон нутгаас ховор нарийн мэргэшлийн эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнийг дэмжих боломж сул 2. Хөдөө орон нутагт нарийн мэргэжлийн эмч нар тогтвор суурьшилтай ажилладаггүй, олдоц муу 3. Нэг эмчид ноогдох сувилагчийн тоо цөөн 4. Орон нутаг ажиллах эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгаа хангагдаагүй /байр орон сууц/ 5. Сувилагч нар ажиллаж буй тасаг, албанаас шалтгаалан үндсэн цалингийн шатлал өөр 6. Гүйцэтгэлийн санхүүжилтээр санхүүжиж байгаатай холбоотой эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын цалингийн тогтолцоог сайжруулах эрх зүйн орчин муу 7. Сургалтын гэрээ байгуулсан ховор нарийн мэргэшил эзэмшсэн эмч гэрээний хугацаанд ажилладаггүй
БОЛОМЖ 1. Улс болон аймгийн түвшинд дэмжлэгт удирдлагатай 2. Гүйцэтгэлд суурилсан үнэлгээ хийх эрх зүйн орчин бүрдсэн. 3. Бүсийн хэмжээнд эрдэм шинжилгээ сургалт судалгаа хийх боломжтой. 4. Улс бүсийн хэмжээнд туршлага солилцох шинэ технологи нэвтрүүлэх нутагшуулах боломж бүрдсэн.	АЮУЛ ЗАНАЛ 1. Чадварлаг мэргэшсэн мэргэжилтнээ хувийн хэвшилд алдах нөхцөл бүрдэж байгаа. 2. Өрсөлдөгч байгууллагын цалин хөлс өндөр тул хүний нөөцийг алдах эрсдэлтэй байна. 3. Өрсөлдөгч байгууллагын тоо олон үйлчлүүлэгчээ алдах эрсдэлтэй. 4. Ховор нарийн мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллуулах нийгмийн баталгааг хангаагүй улмаас хүний нөөцийн хомсдол үүсэх эрсдэлтэй.

Тав. Үйл ажиллагааны ерөнхий чиглэл:

Эмнэлгийн хүний нөөцийн тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлно.

- БОЭТ хүний нөөцийг чадавхжуулах сургалт, хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, суралцагч байгууллага байна.
- Карьер, хөгжлийн болон цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог ажлын бүтээмжийг дээшлүүлэх хөшүүрэг болгох
- Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хүний нөөцийн чадавхийг сайжруулах арга хэлбэр болгох
- Ёс зүй харилцаа хандлага болон хүний эрхийг дээдлэгч байгууллага байна

Зургаа. Хөтөлбөрийн зорилт

Зорилт 1. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байранд сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах

- 1.1 Шинээр бий болгосон болон сул ажлын байрны зарыг олон нийтэд нээлттэй, ил тод зарлана.
- 1.2. Шинэ болон сул ажлын байранд байгууллагын дотоод эх үүсвэр буюу албан хаагчдаас нэр дэвших боломж олгоно.
- 1.3. Ажил горилогчийн анкетыг хүний нөөцийн мэдээллийн санд төвлөрүүлэн “Хүний нөөцийг сонгон шалгаруулах журам”-ын дагуу шийдвэрлэнэ
- 1.4 Тусламж үйлчилгээг тасралтгүй, жигд хүртээмжтэй үзүүлэх шаардлагыг хангах зорилгоор эмч мэргэжилтний албан тушаал, ажлын байр өөрчлөх тохиолдолд шийдвэрийг ил тод мэдээллээнэ.

Зорилт 2. Хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн сан бий болгох, ашиглах үйл ажиллагаанд үнэлгээ хийж сайжруулах

- 2.1. Нийт эмч ажилтаны цаасан болон цахим мэдээллийн санг бий болгоно.
- 2.2. Ажилтныг ажилд орохоос чөлөөлөгдөх хүртэл хугацаанд тухайн ажилтантай холбогдох мэдээллээр хувийн хэрэг үүсгэн тухай бүр баяжуулалт хийнэ.
- 2.3. Хувийн хэрэг бүрдүүлэх, мэдээллийн сан үүсгэх, ашиглах, судалгаа гаргах зэрэг үйл ажиллагаанд байгууллага, хувь хүний нууцыг хадгалана.
- 2.4. Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой алдаа зөрчлийн мэдээний сантай болох, мэдээний сангийн кейс тохиолдлоор мэргэжилтнүүдэд сургамж сургалтыг зохион байгуулдаг болно.

Зорилт 3. Эмч мэргэжилтнийг сургаж хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах

- 3.1. Эмч мэргэжилтнийг сургаж хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- 3.2. Эмч мэргэжилтнийг сургаж хөгжүүлэх хөтөлбөр нь байгууллагын хүний нөөцийн бодлоготой уялдсан байна.
- 3.4. Эмч мэргэжилтнийг сургалтаас олж авсан мэдлэг чадвараа хэрэгжүүлэх нөхцөл бололцоогоор ханган дэмжлэг үзүүлнэ.
- 3.5. Эмч мэргэжилтний төрөлжсөн мэргэжлээр мэргэших, мэргэжил дээшлүүлэх хүсэл сонирхлыг байгууллагын хүний нөөцийн бодлоготой уялдуулан дэмжлэгт удирдлагаар ханган шийдвэрлэнэ.
- 3.6. Мэргэжлийн алба, тэнхим, тасаг нэгжтэй хамтран эмч, сувилагч, тусгай мэргэжилтний эзэмшвэл зохих ур чадварын шалгуур үзүүлэлтийг боловсруулан, уг шалгуур үзүүлэлтийн дагуу сургаж хөгжүүлэнэ.
- 3.7. Төгсөлтийн дараах сургалтыг ажлын байранд тасралтгүй зохион байгуулах эрүүл мэндийн салбарын болон өөрийн байгууллагын мэргэжилтнүүдийг бэлтгэх, чадавхжуулана.
- 3.8. Гадаад, дотоодын сургалтанд хамрагдсан эмч мэргэжилтний мэдлэг туршлагыг бусадтай хуваалцах, түгээн дэлгэрүүлэх, тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх талаар холбогдох албад, мэргэжилтэнтэй хамтарч ажиллана.
- 3.9. Гадаад, дотоодын эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг олон улсын, төрийн, төрийн бус байгууллагуудтай харилцаа холбоо тогтоон мэргэжилтэн солилцох, дэвшилтэт технологи, арга аргачлалаас суралцан өөрийн байгууллагадаа нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллана.

Зорилт 4. Хүний нөөцийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг зохион байгуулах

- 4.1. Хүний нөөцийн хөгжлийн алба нь байгууллагын удирдлагыг хүний нөөцийн эрсдэл үүсч болзошгүй нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээллээр ханган урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- 4.2. Байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх хүний нөөцийн бодлогыг төлөвлөж, эрсдэлд хүргэж болох үр дагаврыг тооцон боловсон хүчний нөөцийг бүрдүүлж ажиллана.
- 4.3. Албан тушаал дэвших, сэлгэн ажиллах, шилжих, чөлөөлөгдөх зэрэг тохиолдлуудад авах арга хэмжээг төлөвлөсөн, нөөцийн бүрдүүлэлт үүсгэсэн байна.

4.4. Эмч ажилтныг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломж, хөшүүргийг буй болгох

4.5. Ажил үүргийн давхардал, ажлын ачааллыг оновчтой хуваарилна.

Зорилт 5. Ажилчдын нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааг зохион байгуулах

5.1. Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

5.2. Засгийн газраас хэрэгжүүлж байгаа орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр, квотод эмч ажилтнуудыг хамруулна.

5.3. Эмч ажилтнуудын цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгоно.

5.4. Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, дэмжих арга хэмжээг жил бүр хэрэгжүүлж үр дүнг тооцно.

5.5. Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийг ҮЭХ, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, орон нутгийн санхүүжилт, хамтын ажиллагааны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ.

Зорилт 6. Байгууллагын соёл, эмч ажилтнуудын ёс зүй, харилцаа хандлагыг төлөвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах:

6.1. Байгууллагын эрхэм зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд эмч ажилтнуудын мэдэж хэрэгжүүлбэл зохих байгууллагын соёлын сургалтыг шинэ ажилтан бүрт зохион байгуулж хэвшинэ.

6.2. Эмч ажилтнуудын ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх сургалтыг жил бүр шинэлэг, дэвшилтэт арга хэлбэрээр явуулана.

6.3. Төрийн албан хаагчийн ба эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, дүрмийг мөрдөх эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг сар бүр тооцон үнэлнэ.

6.4. Хамт олон, үйлчлүүлэгчдийн талархал хүлээсэн эмч ажилтныг сурталчлах үйл ажиллагааг тогтмолжуулана

6.7. Урлаг спорт, экологи, эрүүл мэнд, залуучуудын гэх мэт олон нийтийн арга хэмжээг хамт олныг идэвхжүүлэх хэрэгсэл болгон зохион байгуулах

Долоо: Хөтөлбөрийн санхүүжилт

- Байгууллага
- Төсөв
- Олон улсын байгууллагын хандив тусламж

Найм: Хөтөлбөрийн удирдлага, хяналт-шинжилгээ, үнэлгээ

1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрчимжүүлэх, дүгнэх ажлыг БОЭТ-ийн захирал удирдлага, арга зүйгээр хангаж, хяналт тавьж, Хүний нөөцийн менежер жил бүр хэрэгжилтийг тооцож ажиллана.
2. Хөтөлбөрт тусгагдаагүй хүний нөөцийн хөгжлийн асуудлыг эмнэлгийн дотоод журамд тусгаж хэрэгжүүлнэ.
3. Байгууллагын дотоод хяналтын алба үнэлгээ хийж, зөвлөмж өгнө.

Ес: Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлэх шалгуур
1	Хүний нөөцийн менежментийг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан тушаал шийдвэрийн тоо	Дүрэм, журам, тушаал
2	Хүнийн нөөцийн асуудал хариуцсан багийг сургалтан хамруулсан тоо	Сэдэв, сургалтын тоо, хамрагдсан хүний тоо
3	Шинээр хийсэн, сайжруулсан ажлын байрны тодорхойлолтын тоо	Ажлын байрны тодорхойлолт ба ажлын нэр
4	Сонгон шалгаруулж авсан ажилтаны тоо	Шинээр авсан ажилтны тоо
5	Ажлын гүйцэтгэлийг дүгнэсэн эмч ажилтануудын тоо	Ажил дүгнэсэн протокол
6	Ажлын гүйцэтгэлээр урамшуулж шагнасан хүний тоо	Тушаал, урамшуулал шагнасан мөнгөн дүн
7	Төгсөлтийн дараах сургалтанд хамрагдсан эмч мэргэжилтнүүдийн тоо	Сургалтын сэдэв, хугацаа, кредит, гэрээний хэрэгжилт
8	Эрүүл мэндийн үзлэгт хамрагдалт, эрүүлжилтийн хувь	Үзлэг, шинжилгээний хуудас, дүгнэлт
9	Нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн тоо	• Тэтгэмжинд хамруулсан хүний тоо • Орон сууцанд хамрагдсан хүний тоо • Зээл тусламжинд хамруулсан хүний тоо • Шагнал урамшуулалд хамрагдсан хүний тоо,

Арав. Хүлээгдэж буй үр дүн:

1. Эмнэлгийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, менежментэд дэвшил гарч мэргэжлийн мэдлэг ур чадвартай хүний нөөцөөр хангагдана.
2. Хүнийн нөөцийг оновчтой төлөвлөж хүний нөөцийн хомсдолгүй ажиллана.
3. Эмнэлгийн эрхэм зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн оролцоо нэмэгдэж, тэдний ажлын бүтээмж дээшилнэ.
4. Эмнэлгийн хүний нөөц тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл бүрдэнэ.
5. Гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоо төлөвшиж, байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөө сайжирна.
6. Төвийн эмнэлгийн мэргэжилтний 60-өөс доошгүй хувь нь мэргэжлийн зэрэг, эрдмийн цолтой, 90-аас дээш хувь нь төрөлжсөн мэргэжил эзэмшсэн байна.
7. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хүний нөөцийн чадавхийг сайжруулсан байна.
8. Ёс зүй харилцаа хандлага болон хүний эрхийг дээдлэгч байгууллага болж үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж дээшилнэ.

ХҮНИЙ НӨӨЦИЙН 2023-2025 ОНЫ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

№	Тасаг нэгж	Батлагдсан орон тоо			Шилжилт хөдөлгөөн								
		Эмч	Сувилагч эмнэлгийн мэргэжилтэн	Бусад	2023 он			2024 он			2025 он		
					Эмч	Сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн	Бусад	Эмч	Сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн	Бусад	Эмч	Сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн	Бусад
1	Мэс заслын клиник	9	7						1		1		
2	Эх барих эмэгтэйчүүдийн клиник	9	20						2			1	
3	Хүүхдийн клиник	10	20									1	
4	Дотор-Арьсны клиник	16	16		1			1					
5	Хагалгааны нэгдсэн тасаг	8	17			2						3	
6	Эрчимт эмчилгээний тасаг	3	11										
7	Гэмтлийн тасаг	5	7		1								
8	Чих хамар хоолой, эрүү нүүр, нүдний мэс заслын тасаг	14	13						1		1		
9	Яаралтай тусламжийн тасаг	4	14										
10	Нярай судлалын тасаг	3	11			1							
11	Хавдар, хөнгөвчлөх эмчилгээний тасаг	3	6			1							
12	Сүрьеэгийн тасаг	2	7			1							
13	Уламжлалт, сэргээн засах эмчилгээний тасаг	6	12						1			1	

БОЭТ-ийн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр

33	Статистик мэдээллийн алба	1	2	1	1	1							
34	Үйлчилгээний алба		1	59			3		1	1			
35	Поликлиникийн алба		13	2		1			1				
36	Авто хангамжийн алба			7		2							
37	Санхүү эдийн засгийн алба			8				1					
	Нийт	126	267	120	3	15	5	2	9	1	3	8	2

ТӨГСӨЛТИЙН ДАРААХ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ 2023-2025 ОН /ҮНДСЭН МЭРГЭШИЛ/

№	Он	Мэс засал судлал	Эх барих эмэгтэйчүүд судлал	Дотор судлал	Хүүхэд судлал	Эрчимт эмчилгээ судлал	Гэмтэл согог судлал	Нүд судлал	Чих хамар хоолой судлал	Эрүү нүүр судлал	Яаралтай тусламж судлал	Хавдар судлал	Уламжлалт анаах ухааны засал судлал	Мэдрэл судлал	Сэтгэц судлал	Халдварт өвчин судлал	Эмнэлзүйн эмгэг судлал	Дүрс оношилгоо судлал	Эмгэг судлал	Хүүхдийн нүүр ам судлал	Нүүр амны согог засал судлал	Нүүр амны гажиг засал судлал	Настан судлал	Арьс судлал	Сэргээн засал судлал
1	2023	1				1	1									1	1	2							
2	2024	1	1	1	1			1	1			1	1							1	2	2	1		1
3	2025	1					1							1			1		1					1	

**ТӨГСӨЛТИЙН ДАРААХ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ 2023-2025 ОН
/ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШИЛ/**

№		Суралцах чиглэл	2023	2024	2025
1	Хүүхэд судлал	Хүүхдийн уушги судлал	1		
2		Хүүхдийн хоол боловсруулах тогтолцоо судлал		1	
3		Өсвөр үе судлал			1
4		Хүүхдийн мэдрэл судлал			
5		Хүүхдийн эрчим эмчилгээ судлал			
6	Дотор судлал	Настан судлал	1		
7		Хоол боловсруулах тогтолцоо судлал	1		
8		Зүрх судлал	1		
9		Эмнэл зүйн хоол эмчилгээ судлал		1	
10		Бөөр судлал		1	
11		Үе судлал		1	
12		Цус судлал			
13	Гэмтэл согог судлал	Гавал тархины мэс засал судлал	1		
14		Хүүхдийн гэмтэл судлал		1	
15	Мэс засал судлал	Бүдүүн шулуун гэдэсний мэс засал судлал			1
16		Мэдрэлийн мэс засал судлал		1	
17		Хүүхдийн мэс засал судлал		1	
18	Эх барих эмэгтэйч үүд судлал	Эмэгтэйчүүдийн дотоод шүүрэл, үргүйдэл судлал		1	
19		Эмэгтэйчүүдийн хавдар судлал			1
20		Эх ураг судлал			1
21	Бусад	Хүүхдийн чих хамар хоолой судлал			
22		Эмнэл зүйн дархлаа судлал	1		
23		Эмнэл зүйн хордлого судлал	1	1	
24		Яаралтай тусламжийн дүрс оношилгоо	1	1	1
25		Хөнгөвчлөх эмчилгээ судлал		1	
26		Трансфузиологи			
27		Настны сэтгэц засал судлал		1	
28		Нүдний мэс засал судлал			
		Нийт	8	12	5

ТӨГСӨЛТИЙН ДАРААХ СУВИЛАХУЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ
2023-2025 ОН /ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШИЛ/

№	Суралцах чиглэл	2023	2024	2025
1	Арьсны сувилахуй	1		
2	Гэмтэл согогын сувилахуй	1	1	
3	Дархлаажуулалтын сувилахуй			1
4	Монголын уламжлалт анагаах ухааны бариа заслын сувилахуй		1	
5	Мэдрэлийн сувилахуй		1	
6	Мэдээгүйжүүлгийн сувилахуй		1	
7	Мэс заслын сувилахуй			1
8	Нүдний сувилахуй			1
9	Нүүр амны сувилахуй		1	
10	Нярайн сувилахуй	1	2	1
11	Сэргээн засахын сувилахуй		1	
12	Халдварт өвчний сувилахуй	1	2	
13	Хөнгөвчлөх эмчилгээний сувилахуй			1
14	Хүүхдийн сувилахуй	2	1	1
15	Хавдрын сувилахуй	1		
16	Чих хамар хоолойн сувилахуй			1
17	Эрчимт эмчилгээний сувилахуй			
18	Эх хүүхдийн сувилахуй			
19	Яаралтай тусламжийн сувилахуй			1
20	Дотрын сувилахуй	1	1	1
21	Настны сувилахуй	1		
22	Халдвар хяналтын сувилахуй			1
23	Чихрийн шижингийн сувилахуй			
24	Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуй	1		
25	Жирэмсэн ба төрсний дараах үеийн зөвлөгөө	1		
26	Хөхөөр хооллолтын зөвлөгөө	1		
27	Гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөө	1		
28	Бичил амь судлалын техникч	1		1
29	Клиник биохими судлал		1	1
30	Вирусологи судлал			
31	Серологи судлал			
32	Дархлаа судлал			1
33	Ангиографи судлал	1		1
34	Эмнэлгийн хийн судлал		1	
35	Диализийн тоног төхөөрөмж судлал	1		
36	Нүүр амны гажиг засал судлал	1		
37	Нүүр амны согог засал судлал		1	
38	Эмнэл зүйн эм зүй	1		
39	Эрүүл мэндийн бүртгэл мэдээлэл судлал			1
40	Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдал			
	Нийт	18	15	15